- Бараа материалын дансны үлдэгдэл 306422.8 мянган төгрөг болж өмнөх оноос 74566.9 мянган төгрөгөөр өссөн нь ерөнхий боловсролын сургууль 45225.6 мянга, цэцэрлэг 9897.1 мянга, Эрүүл мэндийн төв 10320.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүлж байна. Энэ нь төсвийн байгууллагууд Ковид-19 цар тахалтай холбоотой эм боох материал, тусгай зориулалтын материал, бусад хангамжийн дансанд эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал халдваргүйжүүлэлтийн материал авч нөөцөлсөн авсантай холбоотой байна.

Хүснэгт № 5. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	3,086.0	4,598.5	1,512.5	1.5
ЗДТГ	62,374.3	68,236.8	5,862.6	22.3
Соёл	29,061.3	30,810.3	1,749.0	10.1
ЭМТ	9,241.2	19,561.4	10,320.3	6.4
ЕБС	78,817.8	124,043.4	45,225.6	40.5
Цэцэрлэг	49,275.4	59,172.4	9,897.1	19.3
НИЙТ ДҮН	231,855.9	306,422.8	74,566.9	100.0

Эх сурвалж: Баянговь сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт нэмэгдсэн 291175.5 мянган төгрөгийн бараа материалын 262521.0 мянган төгрөг нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан, 21654.5 төгрөгийн материал шилжүүлэн авсан, бусад 7000.0 мянган төгрөг тус тус нэмэгдсэн байна. Тайлант онд Эрүүл мэндийн төв аймгийн Эрүүл мэндийн газраас 17011.4 мянга, Ерөнхий боловсролын сургууль БСШУЯ-аас 3423.1 мянга, цэцэрлэг Дэлхийн зөн ОУБ-аас 1220 мянга нийт 21654.5 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус шилжүүлэн авсан байна.

Мөн ЗДТГ сум дундын ойн ангиас 7000.0 мянган төгрөгийн хорголжин тэжээлийн орлого авсан байна.

Хүснэгт № 6. Бараа материалын орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	291,175.5	Хасагдсан	216,608.6
Худалдан авсан	262,521.0	Худалдсан, зарцуулсан	195,045.8
Хандиваар	-	Шилжүүлсэн	-
Шилжүүлсэн авсан	21,654.5		-
бусад	7,000.0	бусад	21,562.8

Эх сурвалж: Баянговь сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 5768091.3 мянга, эцсийн үлдэгдэл 7357144.1 мянган төгрөг болж, 1589052.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БИЕТ ХӨРӨНГӨ	5,701,641.3	7,290,694.1	1,589,052.9	99.1
Барилга байгууламж, орон сууц	4,285,066.0	5,685,741.5	1,400,675.5	77.3
Тээврийн хэрэгсэл	194,760.0	254,760.0	60,000.0	3.5
Машин тоног төхөөрөмж	487,319.5	564,910.5	77,590.9	7.7
Тавилга эд хогшил	222,953.8	259,344.9	36,391.1	3.5
Зам гүүрийн байгууламж	199,800.0	199,800.0	-	2.7
Дуусаагүй барилга байгууламж	-	10,000.0	10,000.0	0.1
Номын фонд	26,673.7	31,069.0	4,395.3	0.4
Бусад үндсэн хөрөнгө	285,068.3	285,068.3	-	3.9
БИЕТ БУС ХӨРӨНГӨ	66,450.0	66,450.0	-	0.9
Программ хангамж	1,750.0	1,750.0	-	0.0
Бусад биет бус хөрөнгө	64,700.0	64,700.0	-	0.9
НИЙТ ДҮН	5,768,091.3	7,357,144.1	1,589,052.9	100.0

Эх сурвалж: Баянговь сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 1589052.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд үүний 90.3 хувь буюу 1435406.7 мянган төгрөгийг хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан нь голлох нөлөө үзүүлж байна Үүнд хүүхдийн цэцэрлэг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1225149.9 мянган төгрөгийн барилга байгууламж шинээр баригдсан, БСШУЯ-аас 33756.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн газраас 149593.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, Ерөнхий боловсролын сургууль БСШУЯ-аас 26906.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл тус тус үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна.

Мөн ЗДТГ нь Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020.01.20-ны өдрийн 02 тоот тогтоолоор аймгийн ОНХС-аар хийгдсэн 1 дүгээр багийн төвийн барилгыг 86197.4 мянган төгрөгөөр, сумын ИТХ-ын 2020.12.31-ний өдрийн 17 дугаар тогтоолоор ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хог тээврийн автомашин 60000.0 мянга, УИХ-н гишүүний багцаас E-mongolia хөтөлбөрийн хүрээнд 4492.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Орон нутгийн хөгжлийн санд цэвэр бохир усны шугам сүлжээ 10000.0 мянган төгрөгийг үнэ төлбөргүй хүлээн авч орлого авсан байна. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 10000.0 мянган төгрөгийн услалтын систем 10000.0 мянган төгрөгийг дуусаагүй барилга байгууламжид бүртгэж авсан байна.

Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	14,356.3	17,056.3	2,700.0	0.2
ЗДТГ	2,490,236.6	2,662,066.5	171,829.9	36.2
Соёл	1,185,351.5	1,186,671.5	1,320.0	16.2
ЭМТ	384,534.6	540,883.5	156,348.9	7.4
ЕБС	1,565,131.2	1,551,409.1	(13,722.1)	21.1
Цэцэрлэг	128,481.1	1,389,387.3	1,260,906.2	18.9
ОНХСан		10,000.0	10,000.0	0.1
НИЙТ ДҮН	5,768,091.3	7,357,474.1	1,589,382.9	100.0

Эх сурвалж: Баянговь сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тухайн онд 77051.9 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авсан, 1435406.7 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан, 170689.9 мянган төгрөгийг бусад байдлаар үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн байна

Мөн Ерөнхий боловсролын сургуулийн 93765.7 мянган төгрөгийн өртөгтэй 40 хүүхдийн хичээлийн байрыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 3 дугаар сарын 4-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор акталсан байна.

Хүснэгт № 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	1,683,148.5	Хасагдсан	93,765.7
Худалдан авсан	77,051.9	Худалдсан	-
Хандиваар		Акталсан	93,765.7
Шилжүүлэн авсан	1,435,406.7	Шилжүүлсэн	-
бусад	170,689.9	Бусад	-

Эх сурвалж: Баянговь сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 2763.5 мянга, эцсийн үлдэгдэл 5034.1 мянган төгрөг болж 2270.6 мянган төгрөгөөр өссөн байна

Хүснэгт № 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН	2,763.5	5,034.1	2,270.6	100.0
Ажилчидтай холбогдсон өглөг	618.7	175.8	(442.9)	3.5
Бараа үйлчилгээний зардлын өглөг	182.9	2,803.6	2,620.7	55.7
Байгууллагад төлөх өглөг	1,306.0	2,054.7	748.7	40.8

Хувь хүмүүст төлөх өглөг	655.9	-	(655.9)	-
Дүн	2,763.5	5,034.1	2,270.6	100.0

Эх сурвалж: Баянговь сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат ер төлбөр нь 5034.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд 72,3 хувь буюу 3644.1 мянган төгрөгийн өглөг нь Эрүүл мэндийн төвийн өглөг байна. Энэ нь тээвэр шатахууны өглөг 2270.0 мянга, эмийн өглөг 533.6 мянга, ХАОАТ өглөг 175.8 мянга, байгууллагад төлөх өглөг 664.7 мянган төгрөг тайлант хугацаанд шинээр үүссэн байна. Хүснэгт № 11. Нийт ер төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ИТХ	257.2		(257.2)	-
ЗДТГ	6.0		(6.0)	-
Соёл	56.5	0.0	(56.5)	0.0
ЭМТ		3,644.1	3,644.1	72.4
СХС	1,300.0	1,390.0	90.0	27.6
ЕБС	794.4		(794.4)	-
Цэцэрлэг	349.4		(349.4)	-
ДҮН	2,763.5	5,034.1	2,270.6	100.0

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 5356699.2 мянга, эцсийн үлдэгдэл 6802474.7 мянган төгрөг болж, 1445775.5 мянган төгрөгөөр төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 12. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,248,819.7	1,248,819.7	-	18.4
Өмч: - төрийн	1,248,819.7	1,248,819.7	-	18.4
Хуримтлагдсан үр дүн	2,868,091.6	4,348,342.1	1,480,250.5	63.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,239,787.9	1,205,312.9	(34,475.0)	17.7
Дүн	5,356,699.2	6,802,474.7	1,445,775.5	100.0

Эх сурвалж: Баянговь сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хуримтлагдсан үр дүн данс 1480250.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 1445775.5 мянган төгрөгөөр өссөн, хөрөнгө акталсантай холбоотой өмнөх үеийн үр дүн 34475.0 мянган төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

Дахин үнэлгээний нэмэгдэл данс 34475.0 мянган төгрөгөөр буурсан нь Ерөнхий боловсролын сургуулийн 40 хүүхдийн хичээлийн барилга акталсан холбоотой 34475.0 мянган төгрөг буурсан байна.

3.5.10 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2019.12.13-ний өдрийн хуралдаанаар 12/14 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 49340.0 мянга, хүү торгуулийн орлогыг 6000.0 мянга, нийт 57240.0 мянган төгрөгөөр анх баталсан ба 2020.09.25-ны өдрийн 14/06 дугаар тогтоолоор татварын орлогод өөрчлөлт оруулаагүй байна.

Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төвлөлгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Татварын орлого	50,240.0	69,518.0	19,278.0	1,303.6
ИОТХ	3,000.0	21,339.5	18,339.5	711.3
Бууны татвар	1,800.0	1,830.0	30.0	101.7
Улсын тэмдэгтийн хураамж	2,000.0	2,144.0	144.0	107.2
Хадгаламжийн хүүгийн орлого	23,000.0	22,487.5	(512.5)	97.8
Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсаны орлого	-	360.0	360.0	-
Газрын төлбөр	2,040.0	1,222.9	(817.1)	59.9

Газрын дуудлага худалдааны орлого	2,000.0	2,000.0	-	100.0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	15,000.0	14,949.5	(50.5)	99.7
ТТАМ ашигласны төлбөр бусад татвар	500.0	630.0	130.0	126.0
2.Татварын бус орлого	900.0	2,554.6	1,654.6	283.8
2.1.Хүү торгуулийн орлого	6,000.0	6,460.0	460.0	107.7
Нийт дүн	6,000.0	6,460.0	460.0	107.7
	56,240.0	75,978.0	19,738.0	135.1

Эх сурвалж: Баянговь сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 19738.0 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл иргэний орлого тодорхойлох хуудсаар тодорхойлсон татварын орлого 18339.5 мянга, бууны албан татвар 30.0 мянга, улсын тэмдэгтийн хураамж 144.0 мянга, ТТАМ ашигласны төлбөр 130.0 мянга, бусад татвар 1654.6 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Иргэний орлого тодорхойлох хуудсаар тодорхойлсон албан татвар 3000.0 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөө батлагдаж гүйцэтгэлээр 21339.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. Энэ нь 2020 оны 12 дугаар сард “Эрдэнэс таван толгой” ХК-ны ногдол ашгийн орлогын суутган татвараас шалтгаалсан байна.

Харин хадгаламжийн хүүгийн орлого 97.8 хувь буюу 512.5 мянга, газрын төлбөр 59.9 буюу 917.1 мянга, хог хаягдлын үйлчилгээний хураамж 99.7 хувь 50.5 мянган төгрөгийн орлого тус тус тасарсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогод Засаг даргын Тамгын газар 1000.0 мянган төгрөгийн орлогоос 1190.0 мянга, соёлын төв 233.0 мянган төгрөгийн орлогоос 233.0 мянган төгрөгийн орлого тус тус орж, ерөнхий боловсролын сургууль орлого төлөвлөөгүй 9000.0 мянган төгрөгийн орлого орсон байна.

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 25000.0 мянган төгрөгөөс 24734.0 мянга, Орон нутгийн хөгжлийн сан 27699.5 мянган төгрөгөөс 6452.0 төгрөгийн орлогыг тус тус оруулсан байна.

3.5.11 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71702, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 2459204.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2304852.8 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас мянган төгрөгийг 2124133.7 урсгал зардалд зарцуулсан бол 180719.1 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Аймгийн СТСХ-ээс авсан судалгаагаар тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн ба Эрүүл мэндийн төв төсвийн төслийг хүргүүлээгүй ба сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019.12.13-ний өдрийн 12/14 дугаар тогтоолоор нийт 2725556.0 мянган төгрөгийг баталсан байна.

Хүснэгт №14. Төсвийн төлөвлөлт байгууллагаар /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төсвийн төсөл	Анх батлагдсан төсөв	Зөрүү
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	41,723.50	77,046.80	35,323.30
Засаг даргын Тамгын газар	500,827.70	411,019.10	-89,808.60
Сургууль	660,370.20	989,622.80	329,252.60

Цэцэрлэг	373,659.60	351,793.90	-21,865.70
Эрүүл мэндийн төв		385,185.60	385,185.60
Соёлын төв	98,063.60	97,837.60	-226.00
Сум хөгжүүлэх сан		136,148.00	136,148.00
Орон нутгийн хөгжлийн сан		276,902.20	276,902.20
Нийт дүн	1,674,644.60	2,725,556.00	1,050,911.40

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардал сумын ИТХ-ын 2019.12.13-ний өдрийн 12/14 дугаар тогтоолоор анх баталсан 2725556.0 мянган төгрөгийг 2020.09.25-ний өдрийн 14/06 дугаар тогтоолоор 13369.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан бол тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зардлыг аймгийн Засаг даргын 2020.11.27-ний өдрийн А/770 дүгээр захирамжаар 13752.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2020.12.30-ний өдрийн А/850 дугаар захирамжаар 107510.8 мянган төгрөгөөр бууруулснаар сумын нийт төсөв 2645167.4 мянган төгрөг болжээ.

Нийт зардлын 1507799.6 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 207989.1 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 648060.4 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 56240.0 мянган төгрөгийг сумын орон нутгийн төсвөөс, 53932.5 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 28929.7 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс, 142216.1 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг бүрэн авч, орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг 1465.9 мянган төгрөгөөр дутуу, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс 1.8 мянган төгрөгөөр дутуу, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтийг 2098.4 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн ба улсын төсөвт 77696.6 мянга, орон нутгийн төсөвт 9621.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №15. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Улсын төсөвт төвлөрүүлсэн	ОН төсөвт төвлөрүүлсэн
ИТХ	75,674.8	74,514.8	1,160.0	98.5		1,160.0
ЗДТГ	409,019.0	400,044.3	8,974.7	97.8		7,698.7
Сургууль	1,005,339.5	951,843.6	53,495.9	94.7	53,162.5	342.4
Цэцэрлэг	296,142.0	277,583.6	18,558.4	93.7	18,253.5	304.9
Соёлын төв	99,390.1	99,374.5	15.6	100.0		15.6
Хүн эмнэлэг	386,185.6	379,803.9	6,381.7	98.3	6,280.6	99.3
СХСан	136,148.0	700.0	135,448.0	0.5		
ОНХСан	237,268.4	213,979.8	23,288.6	90.2		
Нийт дүн	2,645,167.4	2,397,844.5	247,322.9	90.7	77,696.6	9,621.0

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл мянган төгрөг буюу 90.7 хувьтай байгаа нь Ерөнхий боловсролын сургуулийн урсгал зардлыг 53495.9 мянга, сургуулийн өмнөх боловсролын зардал 18558.4 мянга, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг 135448.0 мянга, орон нутгийн хөгжлийн сангийн зардлыг 23288.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 16. Баянговь сумын Засаг даргын төсвийн гүйцэтгэл, хөтөлбөрөөр /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,645,167.4	2,397,844.5	247,322.9	90.7
70105 ОН-ын өөрөө удирдах ёсны байгууллага	75,674.8	74,514.8	1,160.0	98.5
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	62,524.8	61,380.8	1,144.0	98.2
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	1,000.0	984.0	16.0	98.4
80825 Багийн ИНХ-ын даргын урамшуулал	12,150.0	12,150.0	-	100.0
70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	409,019.0	400,044.3	8,974.7	97.8
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	290,131.8	284,634.6	5,497.2	98.1
80106 Баг, хорооны ҮАЗардал	70,289.8	68,951.5	1,338.3	98.1
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	25,812.7	25,812.7	-	100.0
81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	8,500.0	8,496.7	3.3	100.0
82212 Хур хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах	14,284.7	12,148.9	2,135.8	85.0

70503 Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	237,268.4	213,979.8	23,288.6	90.2
80904 Нийгмийн зориулалттай барилга	237,268.4	213,979.8	23,288.6	90.2
71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	386,185.6	379,803.9	6,381.7	98.3
80109 ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	23,683.9	23,584.6	99.3	99.6
80302 Нэг иргэнд ногдох нормативаар	21,784.2	21,105.8	678.4	96.9
81603 үндсэн мэргэжлийн тусламж үйлч	340,717.5	335,113.6	5,603.9	98.4
71702 Соёл урлаг	99,390.1	99,374.5	15.6	100.0
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	97,694.0	97,684.5	9.5	100.0
80214 Уран бүтээл хийлгэх	1,396.1	1,390.0	6.1	99.6
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	300.0	300.0	-	100.0
71801 Сургуулийн өмнөх боловсрол	296,142.0	277,583.6	18,558.4	93.7
80109 ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	33,392.4	33,087.5	304.9	99.1
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	125.6	125.0	0.6	99.5
81807 Цэцэрлэгийн хүүхдийн хоол	18,596.7	18,539.8	56.9	99.7
81832 Нүүдлийн бүлэгт хамруулах	7,698.4	7,698.4	0.0	100.0
81833 Явуулын байшийн үйлчилгээ	4,935.6	111.3	4,824.3	2.3
81834 Боловсролын стандарт, сургалтын үйл ажиллагаа	198,459.0	194,443.4	4,015.6	98.0
81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	32,934.3	23,578.3	9,356.0	71.6
71802 Ерөнхий боловсрол	998,776.3	945,921.4	52,854.9	94.7
80109 ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	93,861.5	93,519.1	342.4	99.6
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	1,712.8	1,712.8	-	100.0
81801 үдийн цай хөтөлбөр	21,248.0	14,865.7	6,382.3	70.0
81806 Дотуур байрны үйлчилгээ	121,741.6	87,228.0	34,513.6	71.7
81834 Боловсролын стандарт, сургалтын үйл ажиллагаа	634,992.3	629,876.1	5,116.2	99.2
81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	125,220.1	118,719.7	6,500.4	94.8
71806 Насан туршийн болон албан бус боловсрол	6,563.2	5,922.2	641.0	90.2
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	6,563.2	5,922.2	641.0	90.2
72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	136,148.0	700.0	135,448.0	0.5
82611 Жижиг дунд үйлдвэрийг дэмжих	136,148.0	700.0	135,448.0	0.5

Эх сурвалж: "Хүрээмарал сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан"

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 4 байгууллага 83472.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 18991.1 мянга, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 57268.9, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 10004.9 мянган нийт 86264.8 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 422.3 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 17. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	ЗДТГ	ЕБС	Цэцэрлэг	ЭМТ	НИЙТ
НИЙТ ОРЛОГО	7,212.9	46,879.1	23,539.7	9,055.4	86,687.2
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,212.9	44,748.0	23,539.7	7,972.2	83,472.9
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		2,131.1		1,083.2	3,214.3
НИЙТ ЗАРЛАГА	6,790.6	46,879.1	23,539.7	9,055.4	86,264.8
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,790.6	2,131.1		1,083.2	10,004.9

Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		18,991.1		18,991.1
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	44,748.0	4,548.7	7,972.2	57,268.9
Төсөвт төвлөрүүлсэн	422.3	-	-	422.3

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 67 мэдээллийг хугацаанд нь, 74 мэдээллийг хугацаа хоцроож, 14 мэдээллийг мэдээлээгүй байна.

Хүснэгт 18. Шилэн дансны мэдээлэл

д/д	хугацаа	төрөл	удаа	хугацаанд нь мэдээлсэн	хугацаа хоцроосон	мэдээлээгүй	Хоцроосон болон хоцроосон мэдээлэл
1	Бүтэн жил	12	12	5	5	2	Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл, дараагийн жилийн төсвийн төсөл, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны тайлангуудийг тус тус хугацаа хоцроосон. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессийн зүйлийн жагсаалт, гүйцэтгэл гэсэн мэдээллүүдийг мэдээлээгүй
2	Хагас жил	3	3	2	1		Санхүүгийн тайлан
3	Улирал бүр	2	8	5	3		Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт 1, 3 дугаар улирал, Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төврөлүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл 1 дүгээр улирал
4	Сар бүр	5	60	29	31		Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл 1,2,3,4,5 дугаар сарууд, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт 1,2,3,4,5,7,8,9,11,12 дугаар сарууд, Улсын төсвийн болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл 1,2,3,4,5,11 дүгээр сарууд, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл 1,2,3,4,5 дугаар сарууд, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнийф төлөвлөгөө, гүйцэтгэл, концессийн зүйлийн жагсаалт, гүйцэтгэл 1,2,3,4,5 дугаар саруудын мэдээллийг тус тус хугацаа хоцроосон.
5	Тухай бүр	6	72	26	34	12	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт 1,2,3,4,5,8,9 дүгээр сарууд, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтын хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг 1,2,3,4,5,7,8,9 дүгээр сарууд, , Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ,

						концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага, үүсгэсэн аливаа шийдвэр 1,2,3,4,5,7,8 дугаар сарууд, Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хэмжээнд орсон өөрчлөлт 1,2,3,4,5,8 дугаар сарууд, Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн 1,2,3,4,5,8 дугаар саруудад тус тус хугацаа хоцроосон байна. Хөрөнгийн урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл 1-12 саруудад мэдээлээгүй байна.
НИЙТ	30	155	67	74	14	

Эх сурвалж. Хүрээмарал сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудас

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 795.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг сумын Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 16-ний өдрийн 118 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна. Хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 19 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	3	795.0	3	795.0			100.0
Нийт	3	795.0	3	795.0			100.0

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгайн сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс бүх байгууллага аудитад хамрагдсан ба 4 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж 4 байгууллагын санхүүгийн тайланд түүвэрт хамруулж 1 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд дүгнэлт гаргасан 4 байгууллага “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяаны төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 70321.2 мянган төгрөгийн 19 алдаа, зөрчил илэрснээс 4486.3 мянган төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 8572.6 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, 19665.4 мянган төгрөгийн зөрчилд менежментийн захидлаар удирдлагад зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 10 заалт бүхий зөвлөмж өгч, 37596.9 мянган төгрөгийн 3 алдааг санхүүгийн тайланд залруулжээ. /Хавсралт 2./

Байгууллагын нэр	нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Санхүүгийн тайланд залруулсан	
	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн
ЗДТГ	4	2,250.0	2	2,000.0			2	250.0		
ЕБС	8	45,365.7	2	2,486.3	2	8,572.6	2	1,019.4	2	33,287.4
Хүүхдийн цэцэрлэг	3	1,520.0					1	1,520.0		
Эрүүл мэндийн төв	4	21,185.6					3	16,876.1	1	4,309.5
Нийт дүн	19	70,321.3	4	4,486.3	2	8,572.6	10	19665.5	3	37,596.9

Баянговь сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 84542.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 5589.8 мянган төгрөгийг 2 алдааг санхүүгийн тайланд залруулж, харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах 78952.6 мянган төгрөгийн 3 зөвлөмж өглөө. /Хавсралт 1./

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

Санхүүгийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд 1520.0 мянган төгрөгийн авлага дутуу, 1520 мянган төгрөгийн бараа материалыг илүү, 2549.8 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийн хуримтлагдсан элэгдлийг дутуу зөрүүтэй нэгтгэсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн төсвөөс санхүүжих урсгал үйл ажиллагааны санхүүжилт 733512.7 мянга, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн 9621.0 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг устгах бичилт хийгээгүй байна

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар аудитлагдсан тайлангийн 2020 оны эцсийн үлдэгдлийг Э-тайлангийн 2021 оны эхний үлдэгдлээр зөв оруулсан эсэхийг нягталж тодруулах шаардлагатай мөн нягтлан бодогч нарын хариуцлагыг дээшлүүлэн санхүүгийн программын эцсийн үлдэгдлийг э-тайлангийн үлдэгдлээр зөв хаалт хийсэн эсэх дээр сумын Санхүүгийн албаны дарга хянаж, дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

4.1.1. Илрүүлэлт: Төсөвт байгууллага, сангийн нягтлан бодогч нар Сангийн яамны Э-тайланд санхүүгийн тайланд хөрөнгө материал, орлого, зарлагын төрлийг зөрүүтэй тайлагнасан, харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагууд нь хөрөнгө материалыг аваагүй байхад тодотгол хийж хөрөнгө бэлтгэхээр ААНБ-д мөнгийг шилжүүлж авлага үүсгэсэн, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээ хийсэн зөрчил санхүүгийн тайлангийн аудитаар илэрч 2 байгууллага “Хязгаарлалттай” дүгнэлт авсан байхад сумын санхүүгийн албаны дарга хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Үнэн зөв байдал, Хэмжилт, Оршин байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 55 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.

4.1.2. Эрсдэл: Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн материаллаг хэмжээний алдаа зөрчлийн дүн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хүлээн зөвшөөрөгдөх материаллаг байдлаас хэтэрсэн байх.

4.1.3 Өгсөн зөвлөмж: Сумын төсөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэл, анхан шатны баримтын бүрдэлд сумын Төрийн сангийн мэргэжилтэн, санхүүгийн тайлангийн үнэн зөв гаргасан байдал, аудитлагдсан санхүүгийн тайланг Сангийн яамны Э-тайланд орлого, зарлагыг данс бүрээр тайлагнаж байгаад санхүүгийн албаны дарга тавьж байгаа дотоод хяналтаа сайжруулах.

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

4.2. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

4.2.2 Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 67 мэдээллийг хугацаанд нь, 74 мэдээллийг хугацаа хоцроож, 14 мэдээллийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг баримтална” гэснийг зөрчсөн байна.

4.2.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо бүрдүүлэхгүй байх.

4.2.3 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулах.

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

4.3. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

4.3.1. Илрүүлэлт:

Сум хөгжүүлэх сангаас олгосон хөнгөлөлттэй зээлийн 78952.6 мянган төгрөгийн үлдэгдлээс 33 зээлдэгчийн 78952.6 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн үлдэгдэл нь 2013-2017 онуудад олгосон гэрээ хугацаа дуусаж хэтэрсэн байхад хяналт тавьж, хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлээгүй байна.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 4.7 “Иргэн, хуулийн этгээд авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө” гэсэн заалтыг зөрчсөн байна

4.3.2. Эрсдэл: Сангийн хөрөнгөөс олгосон зээл гэрээнд заасан хугацаанд төлөгдөхгүй сан хохирох, дараагийн зээлдэгч сангаас зээл авах боломжгүй болох, авлага найдваргүй болох, орлогын төлөвлөгөө тасрах.

4.3.3 Өгсөн зөвлөмж: Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөс хөнгөлөлттэй зээл авч хугацаандаа төлөөгүй 11 зээлдэгчийн 29835.9 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүг 2021 оны 06 дугаар сарын 25-ны дотор төлүүлэх арга хэмжээ авч, заасан хугацаанд төлөөгүй иргэдийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх

4.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 06 дугаар сарын 25-ний дотор нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:

АУДИТОР

Н.БҮНЧИНСҮРЭН 2021.03.25

Анхан шатанд хянасан:
АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ 2021.03.25

Хоёр дахь шатанд хянасан:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ 2021.03.25

5. Хавсралт 1.: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо 2020	Аудитын нэр:	Баянговь сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	Аудитын код: БНА-2021/15/СТА-ТТЗ		
Шалгагдсан байгууллагын нэр:		Баянговь сумын Засаг дарга	Мянган төгрөг		
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	5
1	Санхүүгийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд 1520.0 мянган төгрөгийн авлага дутуу, 1520 мянган төгрөгийн бараа материалыг илүү, 2549.8 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийн хуримтлагдсан элэгдлийг дутуу зөрүүтэй нэгтгэсэн байна.	5589.8	Санхүүгийн тайланд залруулсан	Засаг дарга Санхүүгийн албаны дарга	Б.Мөнхсайхан Г.Гаваа
2	Санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн төсвөөс санхүүжих урсгал үйл ажиллагааны санхүүжилт 733512.7 мянга, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн 9621.0 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг устгах бичилт хийгээгүй байна		Санхүүгийн тайланд залруулсан	Засаг дарга Санхүүгийн албаны дарга	Б.Мөнхсайхан Г.Гаваа
3	Төсөвт байгууллага, сангийн нягтлан бодогч нар Сангийн яамны Э-тайланд санхүүгийн тайланд хөрөнгө материал, орлого, зарлагын төрлийг зөрүүтэй тайлагнасан, харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагууд нь хөрөнгө материалыг аваагүй байхад тодотгол хийж хөрөнгө бэлтгэхээр ААНБ-д мөнгийг шилжүүлж авлага үүсгэсэн, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээ хийсэн зөрчил санхүүгийн тайлангийн аудитаар илэрч 2 байгууллага "Хязгаарлалттай" дүгнэлт авсан байхад сумын санхүүгийн албаны дарга хяналт тавьж ажиллаагүй байна.		Зөвлөмж өгсөн	Засаг дарга Санхүүгийн албаны дарга	Б.Мөнхсайхан Г.Гаваа
4	Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 67 мэдээллийг хугацаанд нь, 74 мэдээллийг хугацаа хоцроож, 14 мэдээллийг мэдээлээгүй байна.		Зөвлөмж өгсөн	Засаг дарга Санхүүгийн албаны дарга	Б.Мөнхсайхан Г.Гаваа
5	Сум хөгжүүлэх сангаас олгосон хөнгөлөлттэй зээлийн 78952.6 мянган төгрөгийн үлдэгдлээс 33 зээлдэгчийн 78952.6 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн үлдэгдэл нь 2013-2017 онуудад олгосон гэрээ хугацаа дуусаж хэтэрсэн байхад хяналт тавьж, хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлээгүй байна.	78952.6	Зөвлөмж өгсөн	Засаг дарга Санхүүгийн албаны дарга	Б.Мөнхсайхан Г.Гаваа
		84542.4			

oOo

6. Хавсралт 2.: Харьяа ТШЗ-ийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт /мянган төгрөгөөр/

Д/д	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мянган төгрөг/	Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	2	3	4	5	6
Баянговь сумын ЗДТГ		2,250.0			
1	Бусад бараа үйлчилгээний зардлаас Санхүүгийн албаны дарга Г.Гаваад сургалтын төлбөрт 1000.0 мянган төгрөг олгосон байна.	1,000.0	Төлбөрийн акт тогтоосон	Дарга Нягтлан бодогч	Д.Отгонжаргал Э.Пүрэвжаргал
2	Баянговь сумын Засаг даргын 2020.04.13-ы өдрийн 35 дугаар захирамжаар бараа үйлчилгээний бусад зардлаас цэрэг татлага зохион байгуулах зардалд 1000.0 мянган төгрөгийг хоол цайны зардлыг шилжүүлсэн байна.	1,000.0	Төлбөрийн акт тогтоосон	Дарга Нягтлан бодогч	Д.Отгонжаргал Э.Пүрэвжаргал
3	Сумын Засаг даргын 2020.11.25-ны өдрийн 92 дугаар захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс ахмадын баярын үйл ажиллагаанд "ГОВЬ ЭКО ФҮҮДС" ХХК-д 250.0 мянган төгрөг шилжүүлж мөнгөн аяга авч шагналд өгсөн байна.	250.0	Зөвлөмж өгсөн	Дарга Нягтлан бодогч	Д.Отгонжаргал Э.Пүрэвжаргал
4	Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 111 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 38 мэдээлэл байна.		Зөвлөмж өгсөн	Дарга Нягтлан бодогч	Д.Отгонжаргал Э.Пүрэвжаргал
Баянговь сумын Ерөнхий боловсролын сургууль		45,365.7			
1	1350.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглагдах жилийг оруулаагүйгээс тайлант жилд элэгдэл бодогдоогүй, 2282.6 мянган төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүнийг бөөн дүнгээр бүртгэсэн.	3,632.6	Албан шаардлага өгсөн	Захирал Нягтлан бодогч	Ц.Буянтогтох, Ж.Золжаргал
2	Цалингийн цэстээр 596899.8 мянган төгрөгийн цалин олгосон байхад үр дүнгийн тайланд зардлыг 13547.7 мянган төгрөгөөр илүү буюу 610447.5 мянган төгрөгөөр тусгасан.	13,547.7	Санхүүгийн тайланд залруулсан	Захирал Нягтлан бодогч	Ц.Буянтогтох, Ж.Золжаргал
3	Аймгийн БСУГ-аас дамжуулан олгосон тэтгэмжийн 19739.7 мянган төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс олгосноор санхүүгийн тайланд тайлагнасан.	19,739.7	Санхүүгийн тайланд залруулсан	Захирал Нягтлан бодогч	Ц.Буянтогтох, Ж.Золжаргал
4	Нягтлан бодогч санхүүгийн программд гүйлгээний утгыг бүрэн оруулдаггүй, шаардах хуудаст гарын үсэг зураагүй, нярвын тайланг хянаж албажуулаагүй, нярав сар бүр материалын тайлан гаргаагүй байна.	1,019.4	Зөвлөмж өгсөн	Захирал Нягтлан бодогч	Ц.Буянтогтох, Ж.Золжаргал
5	Тайлант оны 12 дугаар сард нормын хувцас худалдан авах зардлаас нэг бүр нь 120.0 мянган төгрөгийн 11 эмэгтэй ажлын хувцсыг 1320.0 мянган төгрөгөөр авч бараа материалд бүртгэсэн байна.	1,320.0	Төлбөрийн акт тогтоосон	Захирал Нягтлан бодогч	Ц.Буянтогтох, Ж.Золжаргал
6	Төсвийн хөрөнгөөс хувь хүний орлогын албан татварын илүү шилжүүлсэн 275.9 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийн 890.4 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэн байна.	1,166.3	Төлбөрийн акт тогтоосон	Захирал Нягтлан бодогч	Ц.Буянтогтох, Ж.Золжаргал
7	Аж ахуйн материалд тайлант онд худалдан авсан 460.0 мянган төгрөгийн угаалгын машин, 420.0 мянган төгрөгийн скайнер, 180 мянган төгрөгийн сандал, 1950.0 мянган төгрөгийн 3 ширхэг ус буцалгагч, өмнөх онуудад бэлтгэсэн 1600.0 мянган төгрөгийн булангийн буйдан, 330.0 мянган төгрөгийн угаалгын машин зэрэг үндсэн хөрөнгийг бүртгэсэн байна.	4,940.0	Албан шаардлага өгсөн	Захирал Нягтлан бодогч	Ц.Буянтогтох, Ж.Золжаргал
8	Шилэн дансны тухай хуулийг мөрдөөгүйгээс тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллийн 21.9 хувь буюу 33 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлжээ.		Зөвлөмж өгсөн	Захирал Нягтлан бодогч	Ц.Буянтогтох, Ж.Золжаргал
Баянговь сумын Хүүхдийн цэцэрлэг		1,520.0			
1	Тус байгууллага нь 1520,0 мянган төгрөгийн гал тогооны дагалдах хэрэгсэл гэж 2020 оны 12-р сарын 21нд Тулга техник ХХК-д мөнгө шилжүүлж, материалыг аваагүй авлага үүсгэсэн байна.	1,520.0	Зөвлөмж өгсөн	Цэцэрлэгийн эрхлэгч, нягтлан бодогч	Д.Гансмаа Ж.Золжаргал
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2011 онд боловсруулж мөрдөж ажиллаж байгаа ба тухайн бичиг баримтыг сайжруулах шаардлагатай байна.		Зөвлөмж өгсөн	Цэцэрлэгийн эрхлэгч, нягтлан бодогч	Д.Гансмаа Ж.Золжаргал
3	Шилэн дансны сайтад давхардсан тоогоор нийт 151 мэдээлэл байршуулахаас 126 мэдээллийг хугацаанд нь 25 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.		Зөвлөмж өгсөн	Цэцэрлэгийн эрхлэгч, нягтлан бодогч	Д.Гансмаа Ж.Золжаргал

Баянговь сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Д/д	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мянган төгрөг/	Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	2	3	4	5	6
Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төв		21,185.6			
1	Шилэн дансны сайтад давхардсан тоогоор нийт 151 мэдээлэл байршуулахаас 116 мэдээллийг хугацаанд нь 35 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.		Зөвлөмж өгсөн	Эрхлэгч, нягтлан бодогч	М.Өлзийжаргал Д.Өнөрмөндах
2	Эмийн тайланг гаргаагүй эмийн түүврээр орлого зарлага гаргаж, 16876,1 мянган төгрөгийн эмийг зарцуулсан, мөн тайлан гаргаж анхан шатны баримтыг бүрэн хөтлөөгүй байхад нягтлан бодогч 1107,9 мянган төгрөгийг журналын бичилтээр зардал гаргасан байна.	16,876.1	Зөвлөмж өгсөн	Эрхлэгч, нягтлан бодогч	М.Өлзийжаргал Д.Өнөрмөндах
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөж ажиллах зөвлөмжийг 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн байхад бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.		Зөвлөмж өгсөн	Эрхлэгч, нягтлан бодогч	М.Өлзийжаргал Д.Өнөрмөндах
4	Аймгийн Эрүүл мэндийн газраас авсан тендерийн эмээс 1107,9 мянган төгрөгийн эмийн тайланг нярав гаргаагүй, мөн хандив тусламжаар ирсэн эм болон эмнэлгийн материалын орлогоос 3201,6 мянга, нийт 4309,5 мянган төгрөгийн хөрөнгийг эмийн тайланд орлогыг дутуу бүртгэсэн байна.	4,309.5	Санхүүгийн тайланд залруулсан	Эрхлэгч, нягтлан бодогч	М.Өлзийжаргал Д.Өнөрмөндах
Нийт дүн		70,321.3			

_____оОо_____